



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 26 өдөр

Дугаар А/88

Төгөн

**Түймэртэй тэмцэх ажлыг
зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 31 дүгээр зүйлийн 31.1.1 Гамшгаас хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйл, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйл, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.5, Аймгийн Онцгой комиссын 2022 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2024 оны 08 дугаар сарын 23-ний өдөр тус сумын Мунгараг багийн Сар гэрийн гол, хилийн 319 дүгээр тэмдэгтийн орчим ой хээрийн түймэр илэрч ой, хээрийн түймэр гарсантай холбогдуулан түймэртэй тэмцэх гал түймрийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэг дүгээр хавсралтаар,

2. шаардлагатай үед ой хээрийн түймэрт очих маршрут ажиллагааны журмыг хоёр дугаар хавсралтаар,

3. Ой хээрийн түймрийн бэлэн байдлыг хангах, заавар зөвлөгөө өгч, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Отгонбаатар)-д даалгасугай.

4. Гарах зардлын тооцоог албан байгууллага өөрсдөө гаргах хоол хүнс, унаа, томилолтын зардлыг байгууллагуудын дотоод нөөц хөрөнгөөс гаргахыг Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч (Б.Болдцэцэг), Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч (Б.Баярмаа) Сургуулийн өмнөх боловсролын нягтлан бодогч (Э.Оргилмаа) нарт зөвшөөрсүгэй.

5. Бусад шаардлагатай хөрөнгийг Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хуралд оруулаа. Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Т.Намжилсүрэн)-д зөвшөөрсүгэй.


6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  БАТБАЯР

9072784 6715114394

/Zahiramj/


Сумын Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын 26-ны өдрийн
А/Б тоот Захирамжийн нэг дүгээр
хавсралт



Бүлгийн ажлын хэсгийн нэрс

- 1.Мотоорын Батцогт (Засаг даргын Тамгын газрын дарга) Бүлгийн ахлагч
2. Мягмарын Отгонбаатар (Засаг даргын орлогч) Хангамжийг хариуцна
- 3.Нямдэлгэрийн Намхайбаатар (Хүнс хөдөө аж ахуйн мэргэжилтэн) Холбоо мэдээлэл
- 4.Ганзоригийн Баасан (Улаан тайгын Улсын тусгай хамгаалалттай газар) Газарчин
- 5.Бат-Өлзийн Дүүрэнбаяр (Ойн анги инженер) Бүлгийн ахлагч
- 6.Өвгийн Бөхбат (Эрүүл мэндийн төв) Эрүүл мэнд анхан шатны үйлчилгээ үзүүлэх
- 7.Баянмөнхийн Буянхишиг (Эрүүл мэндийн төв)
- 8.Батсуурийн Бор (Сургуулийн өмнөх боловсролын галч) Гишүүн
- 9.Батхуягийн Нямбаяр (Сургуулийн өмнөх боловсролын галч)
- 10.Иваан Чинбат (Байгаль хамгаалагч) Газарч
- 11.Дамдин Энхбат (Байгаль хамгаалагч) хөдөлмөрийн аюулгүй байдлын зааварчилгаа
- 12.Батхүүний Баттулга (Соёлын төв)
- 13.Галхүүний Тулгаа (Ерөнхий боловсролын сургууль)
- 14.Ц.Даваажав (Ерөнхий боловсролын сургууль)
- 15.Шагдарын Одхүү (Ерөнхий боловсролын сургууль)
- 16.Болд-Эрдэнийн Хишигбат (Хилийн цэрэг)
- 17.Цэндсүрэнгийн Мөнх-Эрдэнэ (Хилийн цэрэг)

Сумын Засаг даргын 2024 оны
08 дугаар сарын ...-ны өдрийн
А/...тоот Захирамжийн хоёр дугаар
Хавсралт



Бүлгийн ажиллах чиглэл, журам

1. Бүлэг 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 9:30 минутад Нэмэлд бэлэн цугларч бэлтгэлээ Сумын Засаг даргад шалгуулна. Бэлэн байдлыг хангасны дараа хөдлөх тушаалаар хөдөлнө.
2. Явах маршрут
Нэмэнгээс –Их билүү өгсөж ёлтоор давж холбоо нуурт үдлээд Мөрөнгийн эхэнд хоноглоно, Мөрөнгийн голыг хавтгай сайраар гарч хярлан хашийг өгсөж Сар гэрийн даваагаар давж сар гэрийн голыг уруудаж дээд хайрлагт хоноглоно. Сар гэрийн голыг уруудаж Тээрмийн голыг гарч уус Сар гэрийн бэлчирт хоноглох бөгөөд түймрийн цэгт хүрнэ.
3. Түймрийн нөхцөл байдалтай танилцаж авах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж яаралтай эргэж холбоонд орж мэдээлэл ирүүлэх.
4. Бүлэг 5 хүнтэй хэсэгт хуваагдаж ахлагчийг томилно.
5. Батлагдсан үүргийг мөрдөж аюулгүйн зааварчилгаа өгч гарын үсэг зуруулах, өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангаж ажиллах үүрэгтэй.

ооо